

**БНСУ ДАХЬ ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВИЙН 2023 ОНЫ 02 ДУГААР САРД ХИЙЖ
ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ТАЙЛАН**

Агуулга: БНСУ дахь Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Үйлчилгээний төв нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын тасаг, Нийгмийн даатгалын тасаг гэсэн 2 тасагтайгаар үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант хугацаанд ажлын чиг үүрэг, хуваарийн дагуу дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

1. *Дотоод ажлын хүрээнд.*
2. *Хөдөлмөрийн гадаад харилцааны ажлын хүрээнд.*
3. *Судалгаа, мэдээллийн ажлын хүрээнд*
4. *Сургалт, сурталчилгааны ажлын хүрээнд*
5. *Хөдөлмөрийн гэрээтэй холбоотой өргөдөл, гомдлын хүрээнд.*
6. *БНСУ-ын Хөдөлмөрийн яам, Хөдөлмөрийн маргаан эцэслэн шийдэх газарт хандаж шийдсэн асуудлын хүрээнд*
7. *Гэрээт ажилчдын ахисан түвшний боловсролыг дэмжих ажлын хүрээнд.*
8. *ХХҮЕГ болон ЭСЯ-аас ирсэн өргөдөл гомдлыг шийдвэрлэх ажлын хүрээнд*
9. *БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж буй иргэдийг нийгмийн даатгалын тэтгэврийн даатгалд албан журмаар хамруулах, Нийгмийн хамгааллын тухай Монгол Улсын Засгийн газар, БНСУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу Монгол Улсын тэтгэврийн даатгалд даатгуулсан гэрчилгээ бичиж олгох*
10. *БНСУ-д оршин сууж буй иргэдийг Монгол Улсын нийгмийн даатгалын сайн дурын даатгалд хамруулах, Нийгмийн хамгааллын тухай Монгол Улсын Засгийн газар, БНСУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу Монгол Улсын тэтгэврийн даатгалд даатгуулсан гэрчилгээ бичиж олгох*
11. *Нийгмийн даатгалын сангийн орлого төвлөрүүлэх ажлын хүрээнд*
12. *БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр (Е-9, Е-8, Н-2 визээр) ажиллах хугацаандаа тус улсын Үндэсний тэтгэврийн даатгалд шимтгэл төлсөн иргэдийн шимтгэлийг олгуулах ажлын хүрээнд*

Тайлангийн хугацаанд тус ХНХҮТ нь Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцааны бодлогын хэрэгжилтийг хангах зорилтын хүрээнд Монгол улс, БНСУ-ын Хөдөлмөрийн Яам хоорондын “Хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох тогтолцоо”-ны дагуу “БНСУ-д ажиллах хүч илгээх тухай харилцан ойлголцлын санамж бичиг”, ХНХЯ-ны эрхлэх асуудлын хүрээнд ажил олгогч, ажилтан хоёрын хооронд байгуулсан хөдөлмөрийн гэрээнд хяналт тавьж биелэлтийг хангуулах, Нийгмийн хамгааллын тухай Монгол Улсын Засгийн газар, БНСУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр, Монгол Улсын Нийгмийн даатгалын ерөнхий газар, БНСУ-ын Үндэсний тэтгэврийн алба хооронд байгуулсан “Харилцан ойлголцлын санамж бичиг”, бусад холбогдох хууль тогтоомжууд болон “Сахилга, хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 01 тоот албан даалгаврыг тус тус хэрэгжүүлэн, БНСУ-д ажиллаж амьдарч буй иргэдийнхээ эрх ашгийг хамгаалахаар ажиллаж байна.

2023 оны 02 дугаар сарын 23-ны өдөр БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллахаар ирсэн 62 иргэнд ирэхээс өмнөх сургалтыг цахим хэлбэрээр зохион байгуулав.

1. Дотоод ажлын хүрээнд:

- Нийгмийн даатгалын лавлагааны програмаас лавлагаа авах хүсэлт гаргасан 17 иргэний мэдээллийг гаргаж өгөв.
- Нийгмийн даатгалын аппликейшнд бүртгүүлэх 8 иргэний хүсэлтийг хүлээн авч, бүртгэлийг баталгаажуулан, иргэдэд бүртгүүлэх кодыг илгээв.
- Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжид заасан болзол нөхцлийг хангасан, нийгмийн даатгалын сангаас тэтгэмж авах эрх үүссэн 5 даатгуулагчид зохих журмын дагуу даатгуулагчийн тодорхойлолтыг гаргаж, шаардлагатай бичиг баримтыг монгол хэл рүү хөрвүүлж өгөв.
- Нийгмийн даатгалын сангийн шимтгэлийн орлогыг НДЕГ-ын Төрийн банкин дахь холбогдох дансанд шилжүүлэн, тайлан мэдээг гарган НДЕГ-ын СБГ-ын холбогдох албан тушаалтанд хүргүүлэв.

2. Гадаад харилцааны ажлын хүрээнд.

- Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ БНСУ-д оршин суугаа монгол иргэдийн төлөөлөлтэй хийсэн уулзалтыг зохион байгуулах ажилд БНСУ-д суугаа Элчин сайдын яамны консулын хэлтэстэй хамтарч оролцов.
- БНСУ-д амьдарч байгаа иргэдэд холбогдох төрийн үйлчилгээг шуурхай хүргэх ажлын хүрээнд 2023 оны 02 дугаар сарын 27-ны өдөр болсон цахим хуралд Цахим хөгжил харилцаа холбооны яам, Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар, И-Монгол академи УТҮГ, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Үндэсний дата төв УТҮГ, Монгол Улсаас БНСУ-д суугаа Элчин сайдын яамны консулын хэлтэс, Пусан хотод суугаа Консулын газар болон ХНХҮТ оролцов.
- БНСУ-ын ХАБЭАХЭГ-ын гадаад хамтын ажиллагааны хэлтэст хандан тус төвтэй байгуулсан хамтран ажиллах “Санамж бичиг”-ийн хугацааг сунгах тухай хүсэлт тавин 2023 оны 03 дугаар сарын 15-ны дотор хэрэгжүүлэхээр тохиролцов.
- БНСУ-ын Үйжонбү Bone гэмтэл согог үе мөчний эмнэлэгтэй хамтран ажиллах “Санамж бичиг” байгуулав. Санамж бичгийн хүрээнд үйлдвэрийн осолд өртсөн монгол иргэдийг тус эмнэлэгт үнэ төлбөргүй эмчлүүлэх, үйлдвэрийн ослын даатгалын нөхөн олговрыг олгуулах, хүнд хүчир ажил хөдөлмөр эрхэлж буй монгол иргэд нуруу нугас болон өвдөг хөл нь гэмтэх өвчлөлд ихээхэн өртдөг тул Үйжонбү Bone эмнэлэгт үнэ төлбөргүй CT, MRI оношилгоо хийлгэх, 100,000 воноос дээш үнэтэй үе мөчний тариаг үнэ төлбөргүй хийлгэх зэрэг манай иргэдэд тустай гэрээ байгуулав.
- 2023 оны 2 дугаар сарын 20-ны өдөр тус тасгаас хамтран ажилладаг “Үри” банктай уулзалт зохион байгуулсан бөгөөд уг уулзалтаар “НДЕГ болон Үри банктай хамтран ажиллах санамж бичиг”-ийг сунгах тухай харилцан санал солилцсон.

3. Мэдээлэл, судалгааны ажлын хүрээнд

- Спас програмаас 2023 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн байдлаар БНСУ-д ирсэн хөдөлмөрийн гэрээт иргэдийн мэдээллийг нэгтгэн гаргав.

4. Сургалт, сурталчилгаа, судалгааны ажлын хүрээнд:

- БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр шинээр ирэх 62 иргэнд ирэхийн өмнөх 2 цагийн сургалтыг 02 дугаар сарын 23-ны өдөр хийв. Иргэдэд:

1. ХНХҮТ-ийн үйл ажиллагааны товч танилцуулга
2. Солонгос улсын хууль, дүрэм, журам
3. Монгол иргэдийн гэмт хэрэгт холбогдож буй байдал
4. Үйлдвэрийн осол, үйлдвэрийн ослын даатгал, ХАБЭ, ослоос урьдчилан сэргийлэх
5. Суугаа орондоо дасан зохицоход анхаарах зүйл
6. Ур чадвартай ажиллах хүч E7 визний талаар
7. Хууль бусаар оршин суухын сөрөг тал, хуулийн дагуу оршин суухын давуу талуудын талаар
8. Нийгмийн даатгал гэсэн сэдвээр гэрээт иргэдэд мэдээлэл, зөвлөгөөг өгч асуусан асуултанд хариулав.

Тайлант хугацаанд нийт давхардсан тоогоор 1108, үүнээс 1088 иргэн, даатгуулагч, ажил олгогчид утсаар, 20 иргэн, даатгуулагчид биечлэн Нийгмийн хамгааллын тухай Монгол Улсын Засгийн газар, БНСУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр, Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжууд, БНСУ-ын Үндэсний тэтгэврийн даатгалаас буцаан олголт авах талаар болон бусад мэдээлэл, заавар, зөвлөгөө өгч, сурталчилгааны материал тараан ажиллав.

5, 6, 7. Хөдөлмөрийн гэрээтэй холбоотой өргөдөл, гомдол, Хууль бусаар ажиллаж буй иргэдийн өргөдөл гомдол, Хөдөлмөрийн маргаан шийдвэрлэх газраар дамжуулан өргөдөл, гомдол шийдэх хүрээнд:

- ХНХТ нь 2023 оны 02 дугаар сарын 01-нээс 02 дугаар сарын 28-ны өдрийн хооронд иргэд байгууллагаас хөдөлмөрийн харилцаанд тулгарсан асуудлаа шийдүүлэхээр танхимаар, факс болон утсаар нийт **142** иргэний санал, хүсэлт, өргөдөл гомдол ирсний дагуу БНСУ-ын Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн яам, Үндэсний тэтгэврийн албатай болон ажил олгогч эздүүд, холбогдох бусад байгууллагуудтай харилцаж, харилцан зөвшилцөх, эвлэрүүлэн зуучлах, гомдол барагдуулах, орчуулга хийх, хууль эрхзүйн зөвлөгөө өгч ажиллав. БНСУ-ын “Самсунг” даатгалын газраас оршин суух хугацаа дуусгавар болсны даатгал, нутаг буцах зардлын даатгал, гэнэтийн ослын даатгал болон үйлдвэрийн ослын даатгал, авч чадаагүй цалин хөлс зэрэг нийт **52,465,554** воныг гэрээт ажилчид болон бусад визээр оршин суугаа иргэд, хууль бусаар оршин суугаа иргэдэд олгуулж ажиллав. Үүнд: Үйлдвэрээс авах 13 дахь сарын цалингийн зөрүү **9,155,554** вон, нутаг буцах замын зардал **2,500,000** вон, Самсунг даатгалын газраас 13 дахь сарын цалинд **22,408,600** вон, дутуу бодогдсон буюу олгогдоогүй цалин хөлс **12,830,000** вон, хууль бусаар ажиллаад цалин хөлсөө авч чадаагүй иргэнд **3,580,000** воныг тус тус холбогдох байгууллагуудаас гаргуулав.

- Төвийн цахим хуудсаар ирж буй өргөдлийг төрөлжүүлэн хүлээн авч, 8 иргэний санал, хүсэлтэнд холбогдох зөвлөгөө мэдээлэл өгөв.

8. Ахисан түвшнийг дэмжих ажлын хүрээнд

- E-9 статусаас E-7-4 рүү визний ангиллаа солиулж ахисан түвшинд хүрэх хүсэлтэй иргэдийг бүртгэлийн санд оруулж, холбогдох сургалтанд бүртгүүлэх, бусад зөвлөгөө мэдээлэл өгч, оноог тоолон ажиллаж байна.

9. БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж буй иргэдийг нийгмийн даатгалын тэтгэврийн даатгалд албан журмаар хамруулах, Нийгмийн хамгааллын тухай Монгол Улсын Засгийн газар, БНСУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу Монгол Улсын тэтгэврийн даатгалд даатгуулсан гэрчилгээ бичиж олгох ажлын хүрээнд

Нийгмийн даатгалын тэтгэврийн даатгалд 36 иргэнийг шинээр хамруулан <https://app.ndaatgal.mn:811/ndweb> програмд мэдээллийг бүртгэн гэрээ байгуулав. Нийгмийн даатгалын тэтгэврийн даатгалд даатгуулсан иргэдэд шинээр 35, гэрээний хугацаа сунгасан 31, ажлын байраа сольсон, гэрчилгээг гээж үрэгдүүлсэн, албан байгууллага нь хүсэлт гаргасан 9 даатгуулагчид Нийгмийн хамгааллын тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу Монгол Улсын тэтгэврийн даатгалд даатгуулсан гэрчилгээг тус тус бичиж олгов.

10. БНСУ-д оршин сууж буй иргэдийг Монгол Улсын нийгмийн даатгалын сайн дурын даатгалд хамруулах, Нийгмийн хамгааллын тухай Монгол Улсын Засгийн газар, БНСУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу Монгол Улсын тэтгэврийн даатгалд даатгуулсан гэрчилгээ бичиж олгох

НДЕГ-ын даргын 2021 оны 3 дугаар сарын 9-ний өдрийн А/35 тоот тушаалын дагуу “Журам шинэчлэн батлах тухай” журмын дагуу тус улсад оршин сууж буй монгол иргэдийг нийгмийн даатгалын сайн дурын даатгалд хамруулж байна.

2 дугаар сарын 28-ны байдлаар сайн дурын даатгалд нийт 813 даатгуулагчийн бүртгэл хийгдсэн ба хувийн хэргийг хөтлөн <https://app.ndaatgal.mn:811/sdkorea/> програмд мэдээллийг тогтмол шинэчлэн, хяналт тавин ажиллав.

Тайлант хугацаанд 27 иргэнийг сайн дурын даатгалд шинээр хамруулж, гэрээ байгуулав. БНСУ-ын ААН-д хөдөлмөр эрхэлдэг 67 даатгуулагчийн хүсэлтийн дагуу Нийгмийн хамгааллын тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу Монгол Улсын тэтгэврийн даатгалд даатгуулсан гэрчилгээг бичиж олгов. Мөн 2023 оны 01 дугаар сарын 31-нээр гэрээ дуусгавар болсон даатгуулагч нарын гэрээг сунгаж ажиллав.

11. Нийгмийн даатгалын сангийн шимтгэлийн орлого төвлөрүүлэх ажлын хүрээнд:

НДЕГ-ын даргын 2023 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн А/04 тушаалаар тус тасгийн 2023 оны орлогын төлөвлөгөө 3,347,614,600.00 төгрөгөөр батлагдсан бөгөөд сар бүрийн орлогын төлөвлөгөө 278,967,883.33 төгрөг болно.

Тус тасаг нь тайлант хугацаанд тэтгэврийн даатгалын шимтгэл 42,180,500.00 вон, сайн дурын даатгалын шимтгэл 43,417,860.00 вон, нийт 85,598,360.00 вон буюу

238,819,424.40 төгрөгийн шимтгэлийн орлогыг төвлөрүүлж, 2 дугаар сарын орлогын төлөвлөгөөг 86 хувийн гүйцэтгэлтэй биелүүлэв. Тэтгэврийн даатгалын буюу <https://app.ndaatgal.mn:811/ndweb/> програм, сайн дурын даатгалын буюу <https://app.ndaatgal.mn:811/sdkorea> програмд даатгуулагчдын мэдээлэл, гэрээний хугацаа, шимтгэл төлөлтийн тооцоог хянан, төлөлт хийлгэж ажиллав.

Хөдөлмөрийн гэрээгээр ажиллагсдын ажил олгогчдод тухайн сарын болон өмнөх саруудын шимтгэл төлөхийг сануулж, 693 ширхэг нэхэмжлэл факсаар илгээн, 873 даатгуулагчтай шимтгэл төлөхийг шаардаж утсаар холбогдов.

Орлогын төлөвлөгөөний биелэлт 2 дугаар сарын байдлаар харуулбал

Хүснэгт-1

/2023.02.28-ны байдлаар, ханш 2.79/

Сар	Сарын орлогын төлөвлөгөө /төгрөгөөр/	Тэтгэврийн даатгалын шимтгэлийн орлого		Сайн дурын даатгалын шимтгэлийн орлого		Нийт төвлөрүүлсэн шимтгэлийн орлого		Биелэлтийн хувь	Тухайн сарын МБ-ны эхний даваа гаригийн хаалтын ханш
		Воноор	Төгрөгөөр	Воноор	Төгрөгөөр	Воноор	Төгрөгөөр		
2	278,967,883.33	42,180,500.00	117,683,595.00	43,417,860.00	121,135,829.40	85,598,360.00	238,819,424.40	86	2.79

12. БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр (E-9, E-8, H-2 визээр) ажиллах хугацаандаа тус улсын Үндэсний тэтгэврийн даатгалд шимтгэл төлсөн иргэдийн шимтгэлийг олгуулах ажлын хүрээнд

БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллах хугацаандаа БНСУ-ын Үндэсний тэтгэврийн даатгалд даатгуулаад нутаг буцсан, төлсөн шимтгэлээ буцааж авахаар НДЕГ-т хүсэлт ирүүлсэн иргэдийн 183 дугаар ээлжийн 4 хүний материал ирснийг УТА-д хүргүүлэн хариуг шийдвэрлүүлэхээр ажиллаж байгаа ба өмнө нь ирүүлсэн иргэдийн 179-182 дугаар ээлжийн хариу ирснийг НДЕГ-т хүргүүлсэн болно.

Хүснэгт-3

/2023.02.28-ны

байдлаар/

№	Нэхэмжилсэн он	Ээлжийн дугаар	Буцаан олголт авсан иргэдийн тоо	Буцаан олгогдсон шимтгэлийн дүн /вон/
1	2022	179	6	27,031,070
2	2022	180	8	35,383,800
3	2022	181	6	19,426,790
4	2022	182	4	30,524,710
Нийт		4	24	112,366,370

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ТАСГИЙН САР ТУТМЫН ТООН МЭДЭЭ /2023 оны 02 дугаар сар/

№	Агуулга	Дүн
1	Иргэдэд олгуулсан мөнгөн дүн	52,465,554 вон
2	Шийдвэрлэсэн өргөдөл, гомдол	142